

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтын явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|----------------|--------------|--|---|--|-------------------|--|-----------------------|
| ЗГ-ын тогтоол | | | | | | | |
| 44 | 59 | Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун- Эрдэнэ орон нутагт ажилласан талаар 2023-10-04 Дугаар 2023_40 | 2.49. Дундговь аймгийн нутагт дэвсгэрт идлэг шонхор шувуу барих, гадаад улсад гаргах квотыг цуцлах хүсэлтийг судлан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат нарт; | Монгол Улсын Засгийн газрын 264 дүгээр тогтоолоор баталсан 2023 онд соёлын зориулалтаар гадаад улсад гаргах идлэг шонхор шувууны тоо хэмжээг баталсны дагуу аймгийн Засаг дарга гадаадын 13 иргэнтэй гэрээ байгуулсан. Тус гэрээ дагуу шонхор барих үйл ажиллагааг Адаацаг, Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Дэрэн сумдад зохион байгуулагдаж 9 шонхрын акт үйлдэгдэж холбогдох төлбөр хураамж сумын дансанд шилжигдэн орсон. Эрдэнэдалай суманд гадаадын иргэн болон нутгийн иргэдийн хоорондын үл ойлголцлоос шалтгаалж тус сумын иргэдийн хүсэлтийн дагуу шонхор барих үйл ажиллагаа зогсож гэрээ цуцлагдсан. | 100 | | |
| | 60 | | 2.51. Дундговь аймгийн Сайнцагаан суманд болсон үерийн хор уршгийг арилгах, сэргээн босгох ажлыг эрчимжүүлэх, хохирсон иргэдэд шаардлагатай туслалцаа үзүүлэхийг Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбатад; | 7-р сарын 23-ний өдөр түр зуурын аадар бороо орсны улмаас аймгийн төвд их хэмжээний үер бууж айл өрх, орон сууц, албан байгууллага усанд автсан. Сумын онцгой комисс хуралдаж мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн үерийн усанд автсан айл өрхүүдийн эд хогшлыг зөөж, нүүлгэн шилжүүлэх ажлыг хийлээ. Сумын онцгой комиссын хуралдаанаар хохирлын үнэлгээг тогтоож улсын онцгой комисст хүсэлт хүргүүлжээ. Үерт өртсөн 31 айл өрхийн хашаа, нүхэн жорлон, 1 албан байгууллага, нийтийн эзэмшлийн талбай, нийт 3500 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийлээ. | 100 | | |

| | | | | | | |
|----|--|---|---|-----|--|--|
| | | | Сумын ОНХС-ийн 18.0 сая хөрөнгөөр үерт автсан зам гудамж талбай гуу жалгыг 1320м3 элс асгаж, үерийн уснаас үүссэн замын эвдрэлийг засаж, овоолго шороог тэгшиллээ. Мөн сумын онцгой комисст ус шавхах 2ш помп авлаа. | | | |
| 61 | | 2.94. Энэ тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар (Б.Баасандорж)-т, хэрэгжилтийн явц, тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим системд оруулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.” гэжээ. | Түр зуурын аадар бороо орох тухай ЦУОШГазраас ирүүлсэн мэдээг сум, багийн пэйж хуудсанд байршуулж сэрэмжлүүлэг мэдээг хүргэсэн. Үерийн үед сумын мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн ажиллаж байгаа мэдээ-2, үерийн дараах арга хэмжээ авсан тухай 4 мэдээллийг сумын пэйж хуудсанд тус тус байршууллаа. | 100 | | |